



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 17 өдөр

Дугаар

4/22

Номгон

「 Аймгийн 2025 оны төсвийн сар, улирлын
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Баянхонгор аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 4/28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг нэгдүгээр, аймгийн төвлөрсөн төсөв, сумдын төсвийн байгууллагуудын төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг хоёрдугаар, сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарийг гуравдугаар, аймгийн төсвөөс сумын төсөвт шилжүүлэх санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг дөрөвдүгээр, сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг тавдугаар, сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д, төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан, батлагдсан төсвийн хүрээнд төсвийг үр ашигтай зарцуулахыг сумын Засаг дарга, орон нутгийн төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Наранбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН 5010053

№	Сум	ИТХ баталсан	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Баян-Овоо сум	360,430.4	0.0	0.0	0.0	0.0	50,000.0	50,000.0	100,000.0	100,000.0	50,000.0	10,430.4	0.0	0.0
2	Баянхонгор сум	4,103,827.9	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	341,000.0	352,827.9	341,000.0
3	Шинэжинст сум	2,174,830.3	0.0	362,471.8	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.9	181,235.4
	НИИТ	6,639,088.6	341,000.0	703,471.8	522,235.9	522,235.9	522,235.9	572,235.9	622,235.9	622,235.9	572,235.9	532,666.3	534,063.8	522,235.4

000

СУМДЫН ТӨСВӨӨС 2025 ОНД АЖИЛГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОПЛОГЫН САР, УЛИРЛЫН ХҮВААРЬ

